

СТАНДАРТ, ХӨМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



**СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ДОТООД АУДИТ ЯВУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Хэрлэн сум

2024.04.29

Нэг. Дотоод аудитын зорилго:

1. Итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаа нь “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагад хэрхэн нийцэж байгааг тогтоох.

2. Удирдлагын тогтолцооны гарын авлага, бусад холбогдох баримт бичиг /дүрэм журмын биелэлт, баримт бичгийн хөтлөлт гэх мэт/-ын шаардлагууд нь ажлын бүх түвшинд хэрэгжиж буй эсэхийг тогтоох.

Хоёр. Хамрах хүрээ

Хөтөлбөрийн дагуу чанарын удирдлагын тогтолцооны элемент нэг бүрийг үе шаттайгаар жилд 1 удаа хамруулна. Эрүүл ахуйн нян судлалын лаборатори, хими хор судлалын лаборатори, ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн лабораторийн шинжээч, лаборант нар.

Гурав. Шалгуур үзүүлэлт

Лаборатори нь үйл ажиллагаагаа MNS ISO/IEC 17025:2018 стандарт, удирдлагын тогтолцооны шаардлагад нийцэж буйг өатлах, өөрсдийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, чанарын бодлого, хөтөлбөрийг тогтмол тасралтгүй хэрэгжүүлэх бодлого баримтлана. Баримтлах бодлогын үндсэн нэг хэлбэр нь дотоод аудит байна.

Дөрөв. Зохион байгуулалт

Лабораторийн эрхлэгч, эрх бүхий албан тушаалтан дотоод аудитын журам, төлөвлөгөөг дээд шатны удирдлагаар батлуулан, бүтцийн нэгж лаборатори тус бүрт удирдлагын тогтолцооны журамд нийцэж буйг батлах зорилгоор дотоод аудитыг зохион байгуулна. Шаардлагатай үед тухайн лабораторитой холбогдолгүй мэргэжлийн боловсон хүчнийг аудитын багт оролцуулж болно.

Тав. Хугацаа :

2024.05.02 - 2024.05.03 ны өдрийн хооронд зохион байгуулна.

Зургаа. Ажлын дараалал

Дотоод аудитын төлөвлөгөөг лабораторийн ажилтнуудад танилцуулж, 2023.05.02 - ны өдөр 10.00 цагт эхлүүлж, 2024.05.03 –ны өдрийн 16.00 цагт дотоод аудитын ажлыг дуусгана.

Долоо. Баримтлах баримт бичиг

MNS ISO/IEC 17025:2018 стандарт, Удирдлагын тогтолцооны журмууд, техникийн шаардлагын журам, лабораторийн дүрэм

Найм.Аудитыг явуулах албан тушаалтан

Ахлах мэргэжилтэн, лабораторийн эрхлэгч, ургамал хорио цээрийн шинжээч, химич шинжээч, микробиологич шинжээч, дээж хүлээн авагч шинжээч

Б. Аудитын үр дүнг танилцуулах:
Дотоод аудитаар илэрсэн үл тохирлыг шалтгаанаас нь хамаарч тодорхой хугацааны дараа зарлуулж тайланг хэлтсийн даргад танилцуулах ба удирдлагын дүн шинжилгээний хурлаар хэлэлцүүлнэ.

Арав. Дотоод аудитын мөөрөө авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- 10.1 Аудитаар илэрсэн үл тохирлын нөхцөл шалтгааныг тогтооно.
- 10.2 Зарлуулах, сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 10.3 Сэргийлэх ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.
- 10.4 Дотоод аудитаар илэрсэн үл тохирлыг заасан хугацаанд зарлуулаагүй шинжээч, лаборант нарыг урьд нь өрсөн үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилтийг үндэслэн, стандарт хэмжил зүйн хэлтсийн даргад танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллана.

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *(Signature)* /Б.ДҮҮРЭНЖАРГАЛ/